- **Байгууллагын соёлыг төлөвшүүлэх ажлын хүрээнд 6 сарын 15-ны өдөр Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороотой хамтраад “Анагаах ухааны боловсрол судлал дахь ёс зүйн тулгуур ухагдахуун”, “Зөрчлийн тухай хууль” сэдвүүдээр** АӨСҮТ-ийн нийт эмч, сувилагч, лаборант, асрагч, тогооч г.м бусад туслах ажилтануудад 2 кредитын сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 52 ажилтан хамрагдсан. Энэхүү сургалтыг ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн хяналтын хорооны Цэрэндагва даргатай баг хийсэн.
- Тасгийн эрхлэгч Г.Цогзол 2018.10.23-нд төвийн хурлын тэнхимд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, ажилчдад 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 11-р сарын 08-ны өдрийн 2/4047 тоот, **Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг** танилцуулсан.



| | | |
|---|---|---|
| | | ➢ ДЭМБ,ЭМЯамтай хамтран “**Эрүүл мэндийн тусламжийн чанар, аюулгүй байдал, ёс зүй”** сэдэвт сургалтыг 2018 оны 11 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, 21 аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн, Ёс зүйн салбар хорооны дарга нарын 63 мэргэжилтнийг хамруулж, туршлага судлах ажлыг зохион байгууллаа<br><br>➢ Чанарын албанаас 2018.11.24-нд “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал” сэдэвт сургалтыг эмч, эмнэлгийн мэргэжилтэн 78 хүнд сургалт явууллаа. |
| 1.7. | Тасаг болон эмч, ажиллагсдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур | ➢ Тасгийн эрхлэгч нарыг дүгнэх шалгуур<br>➢ Үйлчилгээний удирдамж<br>➢ ЭМСайдын 186,187 тушаалын шалгуур |

| | | |
|---|---|---|
| | үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, мөрдөх | ➢ Шилдэг тасаг, их эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, туслах ажилтан, асрагч шалгаруулах үзүүлэлтээр ажиллагсдыг дүгнэсэн. |
| 1.8. | ISO9001 стандартын чанарыг сайжруулах шинэ арга хэрэгслэлийг нэвтрүүлж, үр дүнг тооцож хэвших | 2017- Нийт ажилчдад Удирдлагын академийн багш доктор, профессор Т.Алтанцэцэг “Цагийн менежмент” –ийн талаар сургалт явуулж харилцан ярилцсан. Аяны 1 сарын хугацаанд хурууны хээний цагийн бүртгэлээр хамгийн сайн ирцтэй байсан 4 ажилтанг шалгаруулж урамшуулсан<br><br>2018 онд чанар сайжруулах **“Яг цагтаа”** менежментийг тасаг бүрээр аян өрнүүлэн хэрэгжүүлсэн. Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын ирц, цаг ашиглалт, сахилга хариуцлага, дэг журмыг дээшлүүлэх замаар эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд сэтгэл ханамжтай тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2018.10.01-10.15-ыг хүртэл 14 хоногийн хугацаатай аяныг нийт төвийн тасаг, нэгжийн дунд зарлан дараах ажлуудыг хийлээ.<br>Тасгийн эрхлэгч Г.Цогзол 2018.10.23-нд төвийн хурлын тэнхимд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, ажилчдад 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 11-р сарын 08-ны өдрийн |

2/4047 тоот, **Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг** танилцуулсан.

- Ажилчдын ажлын цагийн ирцийг хурууны хээ уншигч машины бүртгэлээс авч шалгаруулалт хийсэн. Шалгаруулалт хийхдээ тасаг нэгжүүдийн цагийн ирц, ажлын байрны цаг ашиглалт ажиглалтын камерийг үндэслэн түүвэр хийж шалгасан. Бүртгэлийн дүнг нийт ажилчдад эмч Б.Номин-Эрдэнэ, ахлах сувилагч Б.Батцэцэг нар бүртгэлийг нэгтгэн дүгнэж, тасаг нэгжээр нь дүнг гаргаж танилцуулсан. Төвийн 2 ажилтныг ажил үүргээ цагтаа сайн гүйцэтгэж байгаад талархаж хамт олны өмнө сайшаан шагнав. Үүнд:

  1-р тасгийн ахлах сувилагч Д.Оюунчимэг, лабораторийн тасгийн лаборант Нармандах нарыг ажилтаа яг цагтаа ирж ажил үүргээ сайн гүйцэтгэдэг учраас ажлаа үргэлж цагтаа хийж, улам их амжилт гаргахыг хүсэн цагаар шагнаж урамшуулсан.

- Тасгийн их эмч Б.Номин-Эрдэнэ “Эмч, ажилчид эмчилгээ, оношилгоо, сувилгаа”-гаа цагтаа хийдэг эсэхийг үйлчлүүлэгчээс санал асуулгын хуудсаар авч дүгнэн хамт олонд танилцуулахад тасгийн ажилчид харьцангуй эмчилгээ, үйлчилгээг цаг алдалгүй гүйцэтгэдэг гэж 100% хариулсан байлаа.






1. 2017-2018 онуудад **“5 S KAIZEN – 5 САЙН ҮЙЛС”** аяныг жил бүр өрнүүлж **“Хамгийн санаачлагатай” номинацид Клиникийн 2-р тасаг, “Хамгийн хялбар**” номинацид Хүүхдийн тасаг, , **“Хамгийн сонирхолтой”** номинац Сургалтын алба шалгаруулж номинаци тус бүрд “Өргөмжлөл” 150,000 төгрөгийн хамт 3 тасагт, номинаци тус бүр 1 ажилтан шалгаруулж үндсэн цалингийн 15%-г 1 сар олгож нийт 3 ажилтнийг урамшуулж байна.




2. **“Шинэ санаа – Шилдэг арга туршлага”-**ын өдөрлөгийг жил бүр өрнүүлж ажиллагсдын идэвхи санаачлагыг өрнүүлэн чанарын урамшуулал олгодог. Шалгуур үзүүлэлтийн дагуу 5 ажилтанд үндсэн цалингийн 15%, 5 ажилтанд үндсэн цалингийн 10%, 5 ажилтанд үндсэн цалингийн 5% тус тус урамшуулал болгон олголоо.

Үндсэн цалингийн 15%-р:

- Клиникийн 2-р тасгийн эрхлэгч Б.Нандинцэцэг
- ЭГЗНСТасгийн их эмч Б.Баянжаргал

| | | |
|---|---|---|
| | | - Поликлиникийн их эмч Баяртүвшин<br>- Клиникийн 2-р тасгийн асрагч Б.Алтанчимэг нар<br>Үндсэн цалингийн 10%-р<br>- Клиникийн 2-р тасгийн их эмч Ж.Аззаяа<br>- Поликлиникийн тасгийн ахлах сувилагч Б.Батцэцэг<br>- Поликлиникийн тасгийн сувилагч З.Цэцэгмаа<br>- Хүүхдийн тасгийн асрагч Н.Нармандах<br>- Клиникийн 2-р тасгийн сувилагч Б.Пунсалмаа<br>Үндсэн цалингийн 5%-р<br>- Поликлиникийн их эмч Б.Номин- Эрдэнэ<br>- Клиникийн 2-р тасгийн ахлах сувилагч Н.Оюунгэрэл<br>- Клиникийн 1-р тасгийн ахлах сувилагч Д.Оюунчимэг<br>- Клиникийн 2-р тасгийн сувилагч Х.Одсүрэн<br>- Клиникийн 1-р тасгийн асрагч С.Одончимэг нарт урамшуулал олголоо. |
| 1.9. | Хоол зүйчээр харшлын гаралтай өвчнүүдийн үеийн бодит хооллолтын шим тэжээлийн судалгаа явуулж, эмчилгээний хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх | 2017 оноос Хоол зүйч авч ажиллуулсан. Мэргэжлийн хоол зүйч ажиллуулснаар:<br>**<u>Судалгааны ажилууд:</u>**<br>1. Арьсны өвчин судлалын үндэсний төвийн эмч, ажилчдын хооллох зуршил болон антропометрийн үзүүлэлтийн судалгаа<br>2. Арьс харшилын өвчлөлтэй хүн амын хооллолтын судалгаа |

Сувилагч бүр судлаач ОПБХуралд "сувилагчийн эрүүл мэндэд хооллох давтамж хэрхэн нөлөөлөх вэ" сэдэвт судалгаа хийж дэд байр эзэлсэн мөн Сувилахуйн анагаах ухааны боловсрол судлалын эрдэмийн чуулга номонд хэвлүүлсэн.

Арьс судлал хөгжил дэвшил МАӨЭНН-ийн Дөрөвдүгээр Их хуралд

- "Харшилын шалтгаант арьсны өвчтэй хүмүүсийн бодит хооллолт"
- Халдварт бус архаг өвчлөлийн эрсдлийн судалгаанаар оролцож илтгэл тавьсан.

Тасагт эмчлүүлэгчдийн давсны хэрэглээ, мэдлэг, хандлагыг үнэлэх нь судалгааг Нийгмийн эрүүл мэндийн ажилтантай хамтран хийсэн.




**<u>Хоолны цэсэнд өөрчлөлт оруулсан:</u>**

1. Ширээ номер хоолыг өвчлөлийн үеийн хооллолтоор өөрчилж ажилласан.
2. Мөн өглөөний цайны цэсэнд өөрчлөлт оруулсан.

1.Хоолны нэр төрөлд

- Бүхэл үрийн гурил
- Хар талх
- Нэвс гэх мэт зохицуулах үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүнийг нэмэлтээр цэсэнд оруулц өгсөн

| | | |
|---|---|---|
| | | 2.Элэг, цөс, чихрийн шижин даралт гэх мэт хавсарсан өвчтэй хүмүүст зориулан ширээ номер хоолны цэсийг боловсруулсан<br>3. Хоолны технологийн картуудыг шинэчилж ажилласан<br>4. Сар бүр сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг гаргаж тогооч нарт танилцуулж үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.<br>**<u>Өдөрлөг зохион байгуулах оролцох:</u>**<br>1. Тасаг хэвтэн эмчлүүлэгчдэд зохистой хооллолтын сургалтыг сард тогтмол зохион байгуулсан нийт 250 гаруй хүн хамрагдсан байна.<br>2. Янмал оймсны үйлдвэрт: Арьс харшлын гаралт өвчний үеийн хооллолт сургалтыг зохион байгуулсан. Нийт 60 гаруй хүн хамрагдсан.<br><br>3. Зохистой хоол эрүүл амьдрал өдөрлөгийг  Амуу-Үр тариа болон СБЭМТөвийн хоол зүйчтэй хамтран амжилттай зохион байгуулсан. Нийт-56 ажилчид, 70 гаруй үйлчлүүлэгчид сургалтанд  хамрагдсан.<br>4. 2 тасгийн чанарын өдөрлөгт зохистой хооллолт сургалт зохион байгуулсан. |

| | | |
|---|---|---|
| | | 5. Иргэдийн хэрэглээний боловсролын төв, болон сургалтын албатай хамтран эмч, эмнэлгийн ажилчдад “**Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал, зуршил”** сургалтыг зохион байгуулсан.<br>6. Хөхний сүүгээр хооллох 7 хоногийн хүрээнд хүүхдийн тасаг, хөхний сүүний ач тус болон хүүхдийн нэмэлт хоолны сургалт, өдөрлөгийг зохион байгуулж хүүхдийн нэмэлт хоол хийж үзүүлсэн. Мөн гарын авлага материал бэлтгэж тараасан<br>7. **“Үйлчилгээний удирдамж”** сургалтыг гал тогооны ажилчдад зохион байгуулсан. Сургалтын явуулсаны дараа эмчилгээний хоолны тогоочын түгээлтийн үед ажлын хувцас бүрэн өмсөж, үйлчлүүлэгчдэд хоол түгээх үеийн үйл явцад хөндлөнгийн хяналт тавьж ажилласан<br>**<u>Үзүүлэн самбар болон сургалт сурчилгааны гарын авлага:</u>**<br>1. HTV-д  батганы үеийн зөв зохистой хооллолтын талаарх бичлэгт орсон.<br>2. TV болон эрүүл арьс чанартай тусламж мэдээлэлийн самбарт сарт тутамд шинэ мэдээлэл байршуулдаг.<br>Ганцаарчилсан зөвлөгөөг  насны ангилалаар шим тэжээлийн үнэлгээ болон арьс арьсны үед хориглох болон хэрэглэх хүнснийбүтээгдэхүүний талаарх мэдээлэл боршурыг бэлтгэж өгдөг. |
| 1.10 | Чанарын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг “Гантын хүснэгтийн арга”-аар хянах | Чанарын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг “Гантын хүснэгтийн арга”-аар  хийж хянаж байна. |
| 1.11. | Байгууллагын 78 А байранд лифттэй болох | Одоогоор хэрэгжих боломжгүй байна. |

| | | |
|---|---|---|
| ***2-р зорилтын хүрээнд: Халдвар хяналтын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж, эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, дотоод халдвараас сэргийлэх*** | | |
| 2.1. | Дотоод аудиторуудын давтан сургалтад хамруулах | 2018.10. 20-нд **“ISO 9001:2015 стандарт, шаардлагууд”** сэдвээр эмч, ажилтнуудад сургалт явуулсан. /нийт 89 хүн хамрагдсан |
| 2.2. | Халдвараас сэргийлэх үйл ажиллагааг явуулахдаа ЭМСайдын 2014 оны 187 тоот тушаалын 1,2,3,4,5,6-р хавсралтын шалгуур үзүүлэлт, сорилын хуудсаар дүгнэн харьцуулсан дүгнэлт хийж үр дүнг тооцох | Улирал тутамдаа эмнэлгийн нийт тасаг нэгжүүдэд *ЭМС-ын 2017 оны 04 сарын 17–ны өдрийн А/169 тоот тушаалын* дагуу<br>✓ цэвэрлэгээ болон халдваргүйжүүлэлтийн бодисын хяналтын хуудсаар хяналт<br>✓ ариутгалын тасаг, багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл ариутгал хяналтын хуудсуудаар хяналт үнэлгээг хийдэг. Хяналтаар тасгууд хангалттай болон дундаж гэсэн үнэлгээгээр дүгнэгдэж байсан. Хяналтын хуудсыг ХСХ-ын багын хавтаст хийн, хавсаргасан болно.<br>Мөн хагас жил тутамдаа ариутгал халдваргүйтгэлийн Medclean ХХК-аар эмнэлгийн бүх автоклавны үйл ажиллагаандаа хөндлөнгийн хяналт үнэлгээг хийлгэдэг. 2017 болон 2018 онд хийгдсэн дүгнэлтээр тус эмнэлэгт ашиглагдаж буй автоклавуудын цаг болон температураас хамаарсан үзүүлэлтүүд нь спорыг бүрэн устгах хэмжээнд, стандартын шаардлага хангасан байгааг дурьдсан байна. |
| 2.3. | Цэвэрлэгээний тэргэнцэр, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материал угааж хадгалах нөхцөлөөр хангах | Эмнэлгийн бүх тасаг нэгжүүдэд цэвэрлэгээний иж бүрдэл бүхий тэргэнцэр 8 ширхэгийг шинээр авч, тасаг бүрт хуваарилан өгсөн ба цэвэрлэгээний үйл ажиллагаандаа ашиглаж байна.  |

| | | |
|---|---|---|
| 2.4. | 78Б байранд байрлах аппарат тоног төхөөрөмжид аюулгүй ажиллагааны газардуулага хийх | Төвийн хэмжээнд газардуулга хийх шаардлагатай нийт 10 өрөөнд газардуулгыг 2018 онд “АЙ МЕД ХХК”-аар хийж гүйцэтгүүлэв.  |
| **2.5.** | Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний үеийн тусгаарлах өрөө, хувцас, багаж материал эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан нөөцтэй байх, | Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчний үеийн тусгаарлах өрөөг 36 м. Кв талбай бүхий өрөөг гадагшаа шууд гарах гарцтайгаар гаргасан боловч Барилгын зориулалтын бус баригдсан байдлаас хамааран бүрэн стандартын дагуу тохижуулах, хангах боломжгүй байсаар байна. Бид ХӨСҮТөвийн тандалт судалгааны албаны дарга Нямсүрэнгээс 2018 оны 10,11 р сард зөвлөгөө авсаны дагуу Био суултуур, хамгаалах хувцас, багаж материал эм, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан нөөцтэй байхаар бэлтгээд байна. |

| | | |
|---|---|---|
| 2.6. | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд тусгаарлах хувцас өмсгөл өмсөж хэвших | 2017 оны 11-р сарын 16, 17-ны өдрүүдэд тус төвийн эмч, эм зүйч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд “Амилуулах суурь тусламж” сэдэвт сургалыг Улсын нэгдсэн 3-р эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч О.Янжив эмчийг урьж зохион байгууллаа.<br><br>2018 оны 11-р сарын 23-нд Монголын ЯТНийгэмлэгтэй хамтран “Амилуулах суурь болон лавшруулах тусламж” сэдэвт сургалт явуулж 12-р сарын 05-нд тасгуудын эмч, сувилагч нарын дунд тэмцээн зохиогдож Поликлиникийн тасгийн Аврагч 1, Аварагч 2 баг амжилттай оролцож, Тэргүүн, 3-р байр эзлэв. |

| | | |
|---|---|---|
| 2.7. | Угаалга, ариутгалын тасгийн урсгалыг стандартын дагуу болгох | 1. Лабораторийн тасгийн урсгалыг зөв болгох үүднээс лабораторийн цахим бүртгэлээс тусгаарлан шилэн хаалга хийлгэж кодоор нэвтрэх болсон.<br><br>2. Ариутгалын нэгдсэн тасагтай. Ариутгалын тасгийн бохир, цэвэр өгч авах урсгал урсгалыг бий болсон<br><br>3. Угаалгын газар дахь 3 дамжлагатай багтаамж багатай шил сав багтдаггүй шаазан угаалтуур байсныг Стандартын дагуу никель угаалтуураар сольсон. |

| | | |
|---|---|---|
| 2.8. | | <br>4. Ариутгалын тасгийн урсгалыг сумаар заан чиглүүлж өгсөн.<br>Бохир- Цэвэр- Ариун гэж бичигдсэн байгаа.<br>Ариутгасан материал олгох хэсэг<br> |
| 2.8. | Эмийн сангийн дефектарын үйл ажиллагаанд бар код нэвтрүүлэх | Эмийн сангийн дефектарын системийг E-Health программ холбон ажиллуулсаны дараагаар бар кодын системтэй холбон дефектарын үйл ажиллагааг хөнгөвчилөхөөр ажиллаж байна. E-Health |

| | | |
|---|---|---|
| | | программыг суулгах үйл ажиллагаа явагдаж байна. Мөн дефектарын үйл ажллагааны комьютерт Эмиралд санхүүгийн программ суулгасан. |
| ***3-р зорилтын хүрээнд: ЧУТогтолцооны ISO9001:2015 стандартын нэвтрэлтийг сайжруулж, чанарыг тасралтгүй дээшлүүлэх*** | | |
| 3.1. | Нотолгоонд суурилсан эмнэлзүйн удирдамж, стандартыг боловсруулан хэрэгжүүлэх, одоо мөрдөж байгаа стандартад дахин үнэлгээ хийж шинэчлэх | Одоо ашиглаж байгаа 21 стандартыг нийтэд нь дахин хянах улсын үзлэг 2018 оны 09 сард хийгдсэн ба бүх стандартыг дахин хянахаар санал өгөөд байна.<br>- Хайрст үлд, Хамуу, Батга, Арьсны мөөгөнцөрт өвчин, Эмчилгээний гоо заслын клиникийн стандарт, Арьс, эмчилгээний гоо заслын эмчийн үйлдлийн стандарт, Арьс, эмчилгээний гоо заслын өвчний үед хэрэглэх гэрэл болон лазер эмчилгээний стандартууыг шинээр боловсруулах шаардлагатай байна.<br>- 2018 онд ЭМЯамны дэргэдэх сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлөөр “**Хуйхны гүн мөөгөнцөрт өвчтэй хүний үс түүх”**, “**Арьсны өвчтэй хүнд эмчилгээний боолт хийх” зааврыг** хэлэлцүүлэн дараах шатны хурлаар батлуулахаар хэлэлцүүлж байна. |
| 3.2. | Сувилахуйн дадлага, сургалт явуулах өрөө, тоног төхөөрөмжтэй, сургалтыгтогтмолявуулдаг, бүртгэлсудалгаатай болох | ➢ Ур чадварын өрөөнд 5.600.000 төгрөгний 3 муляжыг захиргаанаас авч өгөн сувилагч нарын мэдлэгийг дээшлүүлж байна.<br>➢ Сувилгаанд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн жагсаалт гарган пульсоксиметр 8, хүүхдийн даралтын аппарат 1-г захиалан авч тасаг нэгжид хүлээлгэн өгсөн.<br> |

- 2017 онд ЭХЭМҮТөвийн яаралтай тусламжийн тасагт тус төвийн 1 сувилагчийг 14 хоног “Ажлын байранд дадлагажих сургалтанд”
- 2018 онд УТөв эмнэлгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасагт тус төвийн 2 сувилагчийг “Ажлын байранд дадлагажих сургалтанд” хамруулан мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн ажилласан.
- 2018 оны 04 сарын 05,06-ны өдрүүдэд орон нутгийн сувилагч нарт “**Арьсны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж, хэсэг газрын эмчилгээний онцлог”** сэдэвт 2 өдрийн сургалтыг амжилттай зохион явууллаа.Сургалтанд 18 аймаг, нийслэлийн улсын ба хувийн хэвшлийн арьсны өвчний чиглэлээр тусламж үзүүлдэг 29 сувилагч хамрагдав.



| | | |
|---|---|---|
| | | ➢ **2018.04.19-нд** Чанарын алба, сувилахуйн алба хамтран **“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал” сэдэвт** сургалтыг сувилагч, тусгай мэргэжилтний дунд “Амьд орчин”-ыг бүрдүүлсэн сургалтыг зохион явууллаа.  |
| 3.3. | Сувилахуйн тусламжийг 5 шатлалын дагуу үзүүлдэг, ажлын чанар үр дүнг тооцож ажиллах | - Сувилахуйн зэрэгтэй сувилагч нарын баг “Арьсны өвчний үед мөрдөгдөх сувилгааны онош, сувилгааны төлөвлөгөө” зохиох гарын авлагыг” яаралтай 4 арьсны өвчнөөр шинэчлэн хийж сувилагч нарын гарын авлага болгосон.<br>- Сувилгааны түүх хөтлөлтөөр  |
| 3.4. | Арьсны өвчний хүнд ба хүндэвтэр тохиолдолд Сувилахуйн эмнэл зүйн | - Сувилахуйн албанаас хүнд хүндэвтэр эмчлүүлэгчдийнсувилгаанд анхаарч ажиллан “Сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлэгийг” 2018 онд нийт 10 хүнд 10 удаа хийж, сувилахуйн асуудлыг шийдвэрлэн, жижиг бүлгийн сургалтыг 5 удаа зохион явуулсан. |



| | | |
|---|---|---|
| | хэлэлцүүлгийг хийх, үр дүнг тооцон ажиллах | |
| 3.5. | Эмнэлгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэн **“Танд туслая”** мэдээлэл, зөвлөмжийн өрөөг ажиллуулах | **“Өвчтний аюулгүй байдал”** сэдэвт сургалтын 2017 оны 12 сарын 06-ны өдөр ЭМЯ, УХТЭ-тэй хамтран ЭМЯамны харьяа 16 эмнэлгийн чанарын албаны дарга, чанарын менежер, сувилахуйн албаны дарга нийт 65 хүнд зохион явууллаа. Алдаа эрсдэлээс сэргийлэх зорилгоор **“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төв”** нээн ажиллуулж сувилахуйн албанаас эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд эмийн бодис, тосон түрхлэг, боолт хийх талаар сургалт, зөвлөгөө байнга өгч байна. Хүнсний аюулгүй байдал, хоолноос шалтгаалсан харшлын өвчин, халдварын бус шалтгаанд өвчнөөс сэргийлэх зорилгоор Хоол зүйч байршуулан ажиллаж байна |



**2018 онд  Сэтгэл зүйн  зөвлөгөө өгөн мэдээллээр ханган  ажилласан ажлын тайлан:**

Үйлчлүүлэгчийн аюулгүйн төвд 2018 оны 2 сараас эхлэн баталсан хөтөлбөрийн дагуу 7 хоног бүрийн 3 дахь өдөр бүр 13:00-16:00 цагийн хооронд их эмч Б.Баярмаа зөвлөгөө өгсөн. Үйлчлүүлэгч, эмчлүүлэгч, ажиллагсадыг доорх асуулгын дагуу үнэлсэн:

**Ашиглагдах материал:**

- Одоогийн сэтгэлзүйн байдлыг шалгах арга
- Стресстэй байгаа эсэхээ өөрөө шалгах богино хэмжээний тест

**Шаардлагатай тохиолдолд:**

- Сэтгэл гутрал эмгэгийг оношлох асуулга
- Сэтгэл түгших эмгэгийг илрүүлэх асуулга
- Тайлбарлаж боломгүй биеийн зовиур шаналгааг илрүүлэх асуулга

Үнэлсний дараа доорхи материалыг ашиглан зөвлөгөө өгөн, стресс тайлах аргад сургасан



Тараах материал:

- Стресс гэж юу вэ?,
- Нойрны тухай ,
- Сэтгэл гутрал гэж юу вэ?
- Өөрөөс гаралтай дасгал
-




**ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮН**

| | | |
|---|---|---|
| | | 2018.02.01-2018.10.15-ныг дуустал нийт 99 үйлчлүүлэгч, эмчлүүлэгчидийн сэтгэлзүйн байдлыг үнэлэн, зөвлөгөө өгсөн. Үүнээс эрүүл 59, стресстэй 10, сэтгэцийн тулгамдсан асуудалтай болон эмгэгтэй 22, зөвлөгөө өгсөн 99 байлаа. Тус хугацаанд 12 ажилчдад зөвлөгөө өгсөн. 3 ажилчин стресстэй, 9 нь зөвлөгөө авсан. Зөвлөгөөний сэтгэл ханамж сайн гэж үнэлсэн: 100% |
| 3.6. | Арьсны өвчтэй хүнд хийгдэх сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр заавар, удирдамж боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах | - 2018 онд ЭМЯамны дэргэдэх сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлөөр “Хуйхны гүн мөөгөнцөрт өвчтэй хүний үс түүх” “**Арьсны өвчтэй хүнд эмчилгээний боолт хийх” зааврыг** хэлэлцүүлэн дараах шатны хурлаар батлуулахаар хэлэлцүүлж байна.<br>- Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламжийн журам гарган хэрэгжүүлж эхлээд байна.2018 оны эхний хагас жилд 1 их эмч, 2 сувилагч арьсны өвчтэй 1 хүүхдэд гэрээр нь очиж сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэн, , эцэг эхэд нь зөвлөгөө өгөв.<br>- “Арьсны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж хэсэг газрын эмчилгээ” сэдэвт гарын авлагыг шинэчлэн гарган орон нутгийн сувилагч нарын хүртээл болгосон.<br>- Шинээр ажилд орж буй сувилагч, лаборант нарт “Шинэ сувилагч, Лаборантын гарын авлага” гарган мэдлэгийг баяжуулан, ур чадварыг батжуулан, ажлын байранд 2017 онд 4 сувилагч, 1 лаборант, 2018 онд 2 сувилагч, 4 лаборант нарыг дадлагажуулан ажилласан. |



<table>
<tr><td></td><td></td><td></td></tr>
<tr>
<td>3.7.</td>
<td>Ижил дуудагддаг ижил харагддаг (LAZA) эмийн хэрэглээ, хадгалалтыг сайжруулах</td>
<td>
Эм зүйн албанаас 2017, 2018 онд эмч, сувилагч нарт 2 удаа Эмийн аюулгүй байдал, Ижил дуудагддаг ижил харагддаг (LAZA) эмийн хэрэглээ, хадгалалт сэдвээр сургалт явуулсан.<br>
Эм зүйн алба нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br>
1. Өндөр эрсдэлт эмийн жагсаалттай болсон.<br>
<br>
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ<br>
ӨНДӨР ЭРСДЭЛ ЭМИЙН ЖАГСААЛТ<br>
HIGH ALERT MEDICATIONS LIST
<table>
<tr><th>№</th><th>Эм</th><th>Тун хэмжээ</th></tr>
<tr><td>1</td><td>Магни сульфат</td><td>25%-10мл</td></tr>
<tr><td>2</td><td>Гепарин</td><td>5000ОУН</td></tr>
<tr><td>3</td><td>Аминокапроны хүчил</td><td>5%-100мл</td></tr>
<tr><td>4</td><td>Содын бикарбонат</td><td>8,4%-20мл</td></tr>
<tr><td>5</td><td>Инсулин</td><td>100ОУН</td></tr>
<tr><td>6</td><td>Метотрексат</td><td>2,5мг/мл</td></tr>
<tr><td>7</td><td>Лидокайн</td><td>2%-2мл</td></tr>
<tr><td>8</td><td>Новамин</td><td>8,5%-250мл</td></tr>
<tr><td>9</td><td>Кальци глюконат</td><td>10%-10мл</td></tr>
<tr><td>10</td><td>Морфин гидрохлорид</td><td>1%-1мл</td></tr>
<tr><td>11</td><td>Гентамицин</td><td>80мг-2мл</td></tr>
<tr><td>12</td><td>Реополигюкин</td><td>400мл</td></tr>
</table>
2. Хаягжуулалт<br>
<br>
<br>
HIGH ALERT гэсэн анхааруулах наалтыг эмийн хайрцаг болон ампул тус бүр дээр наан хягжуулсан.
</td>
</tr>
</table>






3. **Хадгалалт**

Эмийн агуулах болон тасаг нэгжүүдэд хадгалж буй эмүүдийг дараах байдлаар хаягжуулан хадгалж байна.

**Эмийн агуулахын өрөө** **Яаралтай түргэн тусламжийн өрөө**





**Looks alike sound alike = LASA**

- Савлагаа
- Хэлбэр дүрс, өнгө нь ижил
- Ижил төстэй бичигддэг
- Ижил төстэй дуудагддаг эмүүдийг ижил харагддаг ижил дуудагддаг эм гэж нэрлэдэг

1. **Ижил харагддаг ижил дуудагддаг эмийн жагжаалттыг гарган тасаг нэгжүүдэд байрлуулсан**






## 2. Хадгалалт хаягжуулалт

- Ижил харагддаг эмнүүд эмийн агуулахад өөр өөр газар хадгалж байна




- Ижил дуудагддаг, ижил харагддаг эм хадгалж байгаа саванд тод өнгөтэй NAME ALERT гэсэн наалт наасан.




- Оригиналь болон женерик эмүүд ихэвчлэн харагдаж ижил дуудагддагийг анхаарч санах
- Эмийг үсгийн дараалаар бус категороор ангилан байршуулах

**Түгээх**

- Эмийг гадна хэлбэр дүрс, өнгөөр бус эмийн нэр, хэрэглэх заалтаар ялгаж тодорхойлж байна
- Эмийн захиалга, эмийн хаяг, эмийг хооронд нь сайн тулгаж шалгаж байна
- Бүх үе шатанд дахин шалгалт хийх / Жор баригч- эм зүйч- сувилагч/

**Мэдээлэх**

- Эмнэлгийн ажилтан бүр ижил харагддаг эмийн нэрсийг мэддэг болсон
- LASA эмийн жагаалтыг тасаг нэгж сувилагчийн мэдээллийн самбар ил байршуулсан
- LASA эмийн жагсаалтыг жил бүр шинэчилж байх
- LASA эмтэй холбоотой алдааг үнэлж дүгнэдэг байх

**Эм найруулах өрөөний зохион байгуулалт**

1. Тосон түрхлэг бүрийг тус бүр тусгай нэг стюбкинд найруулан хэвшсэн. Байрлуулах тавиурыг хаягжуулан яг тэр байранд нь байрлуулж хэвшсэн.

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>


2. Эмийн нунтаг түүхий эд нь бүгд өнгө гадаад байдлаар ижил тул ялгах зорилгоор тосон түрхлэгт ордог түүхий эдийг хадгалдаг штангласны гадна талд ногоон тэмдэг бүхий тэмдэглэгээ тавьсан.





3. Өнгөтэй уусмал найруулахад ордог түүхий эд болон найруулан бэлтгэсэн уусмалыг улаан өнгийн тэмдэг тэмдэглэгээгээр тэмдэглэсэн.
</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | |   |
| ***4-р зорилтын хүрээнд: . Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үр ашиг, үр дүнг тооцож ажиллах*** | | |
| 4.1. | - “Арьсны меланоцит эс шилжүүлэн суулгах”<br>- “Эмнэл зүйн дархлаа – харшил судлал”-аар аутоиммуны өвчны оношилгоо хийх<br>шинэ эмчилгээ, технологийг нэвтрүүлнэ | Япон улсын Киүшүгийн их сургууль, Тайваны Юанг Рунг эмнэлэг, БНСУ-ын Сөүлийн их сургуулиудад суралцуулах гэрээ хийсэн ба арьс цайх өвчний оношлогоо, эмчилгээний орчин үеийн арга барилд суралцуулахаар ажиллаж байна.<br>2018 оны эхний 10 сарын байдлаар БНСУ-ын Сөүлийн их сургуульд 2 эмч суралцуулсан ба 11-р сард Тайваны Юанг Рунг эмнэлэгт 3 эмчийг мэргэжил дээшлүүлэхээр ажиллаж байна. 2019 оны төлөвлөгөөнд тус 3 улсад тус бүр 2 эмч мэргэжилтэнг сургахаар болсон ба арьсны меланоцит эс шилжүүлэн суулгах |

| | | |
|---|---|---|
| | |   |
| 4.2. | Витилиго өвчний эмчилгээнд suction blister техник нэвтрүүлэх. | 2018.08.25-ны өдрийн Арьс судлал-хөгжил дэвшил олон улсын эрдэм шинжилгээний хурлын үзүүлэх сургалтаар Тайваны их сургуулийн эмнэлгийн арьс судлалын тэнхэмийн доктор Жин-Бон Хонг сургалт явуулсан.<br>Цаашид энэ чиглэлээр Тайван улсын Юанг Рунг эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээг 2018 оны хамтран ажиллаж эмч сургахаар 2019 оны төлөвлөгөөнд тусгаад байгаа.<br> |

| | | |
|---|---|---|
| | | |
| 4.3. | Витилго өвчний эмчилгээнд excimer laser эмчилгээг нэвтрүүлэх. | 2018.06.26-наас 07.06-ны хооронд Япон улсын Токио хотын Шинжикү дүүргийн арьсны эмнэлэгт витилиго өвчний excimer laser болон гэрэл эмчилгээний чиглэлээр сургалтанд хамрагдсан.<br>311 нм-ийн богино зурваст гэрэл эмчилгээг арьс цайх өвчний үед хэрэглэх аргыг сайжруулан эмчилгээнд нэвтрүүлсэн.<br>Excimer laser-ийн аппаратыг судлан худалдан авах үнийн саналыг ЭМЯ-ны 2018, 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авахаар хүсэлт гаргаад байна. |
| 4.4. | Эмч, сувилагч тусгай мэргэжилтнүүдээс Ур чадварын шалгалт авах | 2017.10.31 нд “Онолын шалгалт”ыг 30 сувилагчаас авч дүгнэхэд 74,8%, гардан үйлдлийн шалгалтыг 3 өртөөгөөр шалгалтыг авахад тарилга хийх гардан үйлдэлд 78%, яаралтай тусламжийн гардан үйлдэлд 89,8%, сувилгааны түүх хөтлөлтөнд 90,2%-иар тус тус үнэлэгдсэн.<br> <br>Лаборант нараас цус авах гардан үйлдлээр шалгалт авахад цус авах гардан үйлдэлд 83,5%-тай, сорилын шалгалтанд 92,8% тай дундаж үнэлгээгээр 88,3% тай сайн дүгнэгдсэн.<br>Эм найруулагч нараас сорилын шалгалт авахад 92% тай маш сайн дүгнэгдсэн. |

| | | |
|---|---|---|
| | | 2018 онд MNS 4621:2008 стандартын дагуу 2 удаа шалгахад бага эрсдэлтэй үнэлэгдсэн болно. 2018 оны 11-р сарын 23-нд Монголын ЯТНийгэмлэгтэй хамтран “Амилуулах суурь болон лавшруулах тусламж” сэдэвт сургалт явуулж 12-р сарын 05-нд тасгуудын эмч, сувилагч нарын дунд тэмцээн зохиогдож Поликлиникийн тасгийн Аврагч 1, Аварагч 2 баг амжилттай оролцож, Тэргүүн, 3-р байр эзлэв |
| 4.5. | Эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнийг мэргэжлийн зэргийн шалгалтанд тогтмол хамруулж, зэрэгтэй эмч мэргэжилтний тоог нэмэгдүүлэх | 2017 оны байдлаар Эмч нар: Ахлах зэрэгтэй-11 Тэргүүлэх зэрэгтэй-9 АУМагистр-16 Клиникийн профессэр-5 Боловсрол, Хууль, Эмзүйн магиструуд тус бүр 1 АУДоктор-1 ШУДоктор-1 Магистрант-6 Докторнт-4 Сувилагч нар: Ахлах зэрэгтэй- 8 Тэргүүлэх-3 СУ-магистр-1 АУ-магистр-1 ХЗУ-магистр-1 байна. 2018 оны эхний 10 сарын байдалаар Эмч нар: Тэргүүлэх зэрэтэй-1 Клиникийн профессор-2 Сувилагч нар: Ахлах зэрэгтэй- 2 Тэргүүлэх-2 СУ-магистр-1 АУ- магистр-1 ХЗУ-магистр-1 нэмэгдсэн байна. |
| 4.6. | Арьс гоо заслын чиглэлээр өндөр хөгжилтэй орнуудаас багш, мэргэжилтэн урьж сургалт, семинар зохион байгуулах, эсвэл сургалтыг зайн хэлбэрээр зохион байгуулах | 2018 оны 8-р сарын 24,25 өдрүүдэд “Арьс судлал хөгжил дэвшил” олон улсын IV-р их хурал зохион байгуулж ОХУ-аас РУДН Их сургуулийн харшил дархалаа судлалын тэнхэмийн профессор Н.С. Таурщикова Тайван улсын Тайваны их сургуулийн эмнэлгийн арьс судлалын тэнхэмийн доктор Янг Шиа Даи, Жин-Бон Хонг нар оролцож сонирхолтой лекц тавьсан.  |

| | | |
|---|---|---|
| | | 2018 оны 9 сарын 3,4,5ны өдрүүдэд Тайван улсын Цэргийн нэгдсэн эмнэлэгийн арьс судлалын тэнхэмийн эрхлэгч Вэи-Минг Ванг үзлэг, сургалт явуулсан.<br> |
| 4.7. | "Эмнэлэг – Зочид буудлын үйлчилгээ"-г нэвтрүүлэх | • 2018 оны 3 улиралд амбулаторийн гэрэлтүүлэгийг 100 хувь шинэчилж сүүлийн үеийн гэрэлтүүлэгээр бүрэн шинэчилсэн.Мөн 2018 оны 4-р улиралд 1 –р тасгийн дотор засварыг хийж гэрэлтүүлэгийг сайжруулахаар ажиллаж байна.Хэвтэн эмчлүүлэгчийн палатуудын хаягийг<br>• Цахимаар дугаар авах үйлчилгээг 2018 оны 4 –р улиралд багтаан вэб сайтаар дамжуулан дугаар авах үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.<br>• Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд утасгүй интернетийн үйлчилгээг цагийн хязгаартай үзүүлж байна.<br>• Тус төвийн хэвтэн эмчлүүлэх тасаг болон амбулаториор үйлчлүүлэх иргэдэд такси үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. |

| | | |
|---|---|---|
| | | • Хэвтэн эмчлүүлж буй болон, амбулаториор үйлчилүүлж буй иргэд, болон төвийн ажилтан албан хаагчидад банкны үйлчилгээг ойртуулах зорилгоор хаан банкинд хүсэлт гаргасаны дагуу 2018 оны 1-р улирлаас тус банкны орлого, зарлагын гүйлгээ хийдэг АТМ байршуулсан.<br>2018 оны 2 улиралд тус төвийн видео, цаасан танилцуулгыг шинэчлэн, вэб сайт, болон фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд түгээж байна. |

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл | Үйл ажиллагаа | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | 1-р зорилтын хүрээнд | 11 | |
| 2. | 2-р зорилтын хүрээнд | 8 | |
| 3. | 3-р зорилтын хүрээнд | 7 | |
| 4. | 4-р зорилтын хүрээнд | 7 | |